



ТӨВ АЙМГИЙН
БАЯНХАНГАЙ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 09

Улаанхад

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн бүртгэлд
2024 оны 06 сарын 11-ны
өдрийн 6847 дугаарт бүртгэв.

Малын тоо толгойн албан татвар
тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.4, 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.17, 48 дугаар зүйлийн 48.1, Малын тоо толгойн албан татварын хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 38 дугаар зүйлийн 38.1, 38.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сумын хэмжээнд өвөлжилт хаваржилтын байдал хүндэрсэний улмаас нийт мал сүргийн 10.2 хувь хорогдсон. Иймд малчдын амьжиргааг дэмжих зорилгоор малчин мал бүхий иргэдэд оногдуулсан 2024 онд Төв аймгийн Баянхангай сумын малчин мал бүхий иргэдээс авах малын тоо толгойн албан татварыг дараах төрөл хэмжээгээр тогтоосугай.

Үүнд:

Тэмээ 0 төгрөг
Адуу 0 төгрөг
Үхэр 0 төгрөг
Хонь 0 төгрөг
Ямаа 0 төгрөг

2. Энэхүү тогтоолыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба (Д.Хажидсүрэн)-д үүрэг болгосугай.

3. Сумын иргэдийн 2022 оны 2-р сарын 25 ны өдрийн 02 тоот малын тоо толгойн албан татвар тогтоох тухай тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА  Д.МӨНХБАТ

~12401031

D:/2024 togtool



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024.06.11 № 1/2025

танай 2024.05.28-ны № 05/61 -т

**ТӨВ АЙМГИЙН БАЯНХАНГАЙ
СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА
Д.МӨНХБАТ ТАНАА**

“Малын тоо толгойн албан татвар тогтоох тухай” Төв аймгийн Баянхангай сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 09 дүгээр тогтоолыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзээд, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн6847..... дугаарт бүртгэж хүргүүлэв.



Б.ЭНХБАЯР

151602486
Doc.yam a5.2024



ТӨВ АЙМГИЙН БАЯНХАНГАЙ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2021 он 02 сарын 18 өдөр

Дугаар 02

Улаанхад

Малын тоо толгойн албан татвар
тогтоох тухай

Сумын малын тоо толгойн албан татварын хэмжээ тогтоох тухай сумын Засаг дарга С.Баярмаагийн мэдээлэл, өргөн мэдүүлсэн төсөл, түүнд Хурлын Эдийн засаг, төсөв санхүүгийн хуралнаас хийсэн дүгнэлтийг хэлэлцээд, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4, Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь заалт, Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус III хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Малчин, мал бүхий этгээдийн нэг толгой малд ногдуулах албан татварын хэмжээг дор дурдсанаар тогтоосугай.

Үүнд:

Тэмээ	1000 төгрөг
Адуу	1000 төгрөг
Үхэр	600 төгрөг
Хонь	500 төгрөг
Ямаа	500 төгрөг

2. Мал бүхий этгээдийн малын толгой тутамд ногдуулах албан татварын хэмжээг энэ тогтоолын 1-д заасантай адил хэмжээгээр тогтоосугай.

3. Малын тоо толгойд ногдуулсан албан татварыг 2021 оны 4 дүгээр сараас хойш, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 7.1-д заасан хугацаанд төлүүлэх нь зүйтэй гэж үзүгэй.

4. Малын тоо толгойн албан татварын тухай хууль, энэ тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, малын тоо толгойн албан татварын орлогыг сумын жил бүрийн төсөвт оруулан батлуулах, сумын орхон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэн Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8-д заасан зориулалтаар зохих журмын дагуу зарцуулахыг сумын Засаг дарга /С.Баярмаа/-д даалгасугай.

5. "Малын тоо толгойн албан татвар тогтоох тухай" тогтоолыг Хууль зүй дотоод хэргийн хаманд хүргүүлэн, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэн нэрлүүлэх арга хэмжээ авахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга Д.Батбаяр/-д даалгасугай.

6. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид үүрэг болгосугай.

ДАРГА



Д.МОНХБАТ

00162